



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 11 сарын 27 өдөр

Дугаар А/66

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 18/03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүүхдэд ээлтэй хүний хөгжлийг дэмжих жилийн хүрээнд Ховд аймгийн холбооны газрын хийж гүйцэтгэсэн ерөнхий боловсролын 18 сургуулийн дотуур байранд “Итгэлтэй утас” суурилуулах зардалд 24,993,000 төгрөгийг хавсралтаар баталж, зарцуулсугай.

2. Зардалд зарцуулагдах 24,993,000 (Хорин дөрвөн сая есөн зуун ерэн гурван мянга) төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний 5.1 дэх заалт Боловсролын салбарын хөтөлбөр “Тогтвортой хөгжлийн боловсрол” дэд хөтөлбөрөөс тооцож гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Батнасан), Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Б.Гомбосүрэн) нарт зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Сандагсүрэн)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



М.АМАРСАНАА

8400001-2008

Zah.A/66.Ba

Засаг даргын 2024 оны
11 дүгээр сарын 27-ны өдрийн
А/66 дугаар захирамжийн хавсралт

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ДОТУУР БАЙРАНД
“ИТГЭЛТЭЙ УТАС” СУУРИЛУУЛАХ ЗАРДЛЫН ТӨСӨВ

Д/д	Байгууллага	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Материалын зардал	Үйл ажиллагааны зардал	Нийт зардал
1	2	3	4	5	6	7
1	Ерөнхий боловсролын сургууль (дотуур байр)	ш	18	15,147,000	9,846,000	24,993,000
Нийт дүн						24,993,000

-оОо-